

Агуулга

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	2
2. МӨРДӨХ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД.....	2
3. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ, ТАЙЛБАР	3
4. ЗАМЫН ТЭМДЭГ ТОНОГЛОЛЫН БОЛОН ЗАМЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН АРЧЛАЛТ	3
5. ЗАМЫН ТЭМДЭГ ТОНОГЛОЛЫН БОЛОН ЗАМЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН УРСГАЛ ЗАСВАР.....	6
6. ЗАМЫН ТЭМДЭГ ТОНОГЛОЛЫН БОЛОН ЗАМЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ЭЭЛЖИТ ЗАСВАР	8
7. ЗАМЫН ТЭМДЭГ ТОНОГЛОЛЫН БОЛОН ЗАМЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ИХ ЗАСВАР	10

АВТО ЗАМЫН ТЭМДЭГ ТЭМДЭГЛЭГЭЭ, ТОНОГЛОЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛАМЖИЙН АРЧЛАЛТ, ЗАСВАРЫН АРГАЧИЛСАН ЗААВАР

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Авто замын тэмдэг тэмдэглэгээ, тоноглол, үйлчилгээний байгууламжийн арчлалт засвар нь Авто замын хөдөлгөөн зохион байгуулах үндсэн үйл ажиллагаанд хамаарагддаг бөгөөд “Авто замын тухай”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай” хуулиудад нийцсэн байна.
- 1.2. Авто замын хөдөлгөөн нь жолооч-машин-орчин гэсэн 3 орон зайд хамааран үргэлжилдэг, түүний орчин гэдэгт замын хучлагын байдал, замын үзэгдэх зай, замын тоноглол орж хөдөлгөөнийг аюулгүй зохион байгуулах үүрэг гүйцэтгэнэ.
- 1.3. Энэхүү заавар нь замын хөдөлгөөний орчны нэг чухал хэсэг болох авто замын тэмдэг тэмдэглэгээ, заалт, замын хөдөлгөөний хамгаалалтын тоноглол, аюулгүйн зурвас, зогсоол, жолооч зорчигчдод үйлчлэх үйлчилгээний байгууламжууд, төлбөр авах цэг, замын үзэмж дээшлүүлэхэд чиглэгдсэн хийц хэсгүүдийн арчлалт, засварыг зохион байгуулах, гүйцэтгэх, хянахад чиглэгдэнэ.
- 1.4. Авто замд тогтмол хийгддэг үзлэгийн бүрэлдэхүүнд Авто замын тэмдэг тэмдэглэгээ, тоноглол, үйлчилгээний байгууламжийн ашиглалтын байдал ордог бөгөөд, авто замын үзлэгийн аппликейш (Road Inspection)-ны “эвдрэлийн код”-д нэг бүлэг болж орно.

2. МӨРДӨХ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД

- 2.1. Авто замын тухай хууль
- 2.2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль
- 2.3. Авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажлын зохион байгуулалтын журам
- 2.4. Авто замын дагуух үйлчилгээний цогцолбор. Ангилал, ерөнхий шаардлага MNS 5537-2016
- 2.5. Авто замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага MNS 4759 : 2014
- 2.6. “Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4597 : 2014
- 2.7. “Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм” MNS 4596 : 2014
- 2.8. Авто замын тэмдэг болон дохионы төмөр бетон шон. Техникийн шаардлага MNS 4912 : 2016
- 2.9. Авто замын тэмдэгний өнгөний код. Техникийн шаардлага. MNS FED ST 595 C : 2016
- 2.10. Шон суурьтай замын тэмдэг. Замын гэрэлтдэг тэмдэг MNS EN 12966 : 2016
- 2.11. Авто зам ба авто зогсоолын хучлагын ашиглалтын төлөвийн тоон үнэлгээний арга MNS ASTM D 6433 : 2009
- 2.12. Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм MNS 4596 : 2014
- 2.13. Авто замын тэмдэгний гэрэл ойлгогч болон будаг, лак зэрэг өнгөлгөөний бусад материалын чанарт тавих хяналт, дээж авах, турших арга FED ST 141D-2015
- 2.14. Авто замын үзлэгийн аппликейшн – Road Inspection

3. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ, ТАЙЛБАР

- 3.1. **Замын тэмдэг** гэж, замын хөдөлгөөн зохицуулах зорилгоор замын зурваст холбогдох стандарт, техникийн шаардлагад заасны дагуу тавьсан анхааруулах, хориглох, заах, дараалал тогтоох, зохицуулах, мэдээлэх г.м замын хөдөлгөөний дүрмээр зөвшөөрөгдсөн тэмдэг заалтуудыг хэлнэ.
- 3.2. **Замын тоноглол** гэж, зам хэрэглэгчдийн аюулгүй байдлыг хангах замын овор хэмжээг тодорхойлон хязгаарласан, жолооч нарт чиглэл өгсөн, болзошгүй ослоос урьдчлан сэргийлэх, хамгаалах зорилго бүхий дохиолол, зохицуулалтын хийцүүдийг хэлнэ.
- 3.3. **Замын дэргэдэх үйлчилгээний байгууламж** гэдэгт, жолооч зорчигчдод үйлчилгээ үзүүлдэг бүх байгууламжууд орох бөгөөд үүнээс зам хариуцагч байгууллагын шууд хяналтад байдаг, бүх төрлийн жижиг, том зогсоолууд, автобусны буудал, хурд шилжүүлэх зурвасууд, бие засах газрууд, ариун цэврийн байгууламжууд, хог хүлээн авч ангилах цэг, төлбөр авах цэг (ТАЦ), хяналтын төхөөрөмжүүд г.м бүх авто замтай холбоо бүхий бүх байгууламжууд орно.
- 3.4. **Замын тэмдэглэгээ** гэж замын хөдөлгөөнд тодорхой горим, журам тогтоох зорилгоор зорчих хэсэг болон түүний хашлага дээр хийсэн шугам, сум, дүрс, бичлэгийг хэлэх бөгөөд эдгээр нь хэвтээ тэмдэглэлд хамаарна. Хэвтээ тэмдэглэлийг дангаар нь буюу замын тэмдэг, гэрлэн дохио болон бусад техник хэрэгсэлтэй хослуулан хэрэглэнэ.

4. ЗАМЫН ТЭМДЭГ ТОНОГЛОЛЫН БОЛОН ЗАМЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН АРЧЛАЛТ

- 4.1. Замын тэмдэг, тоноглолын байдалд үзлэг хийж, үзлэгийн журнал хөтлөх, үзлэгийн мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулах
- 4.2. Замын тэмдэгийн арчилгаа тордлого, хамгаалалт, алга болсон замын тэмдэгийг дахин тавих, эвдэрснийг солих
- 4.3. Ховхорч холцорсон хэвтээ болон босоо тэмдэглэгээг арилгах, хуучныг сэргээх, шинээр хийх, шаардлага хангахгүй хуучирсан тэмдэг заалтуудыг солих, шаардлагатай тэмдэгүүд, хамгаалалтын хашлага, чиглүүлэх хийцүүдийг нэмэх
- 4.4. Авто замын арчлалт, засварын үед болон замын далан угаагдаж нарийссан, томоохон саад зам дээр бий болсон үед үед түр дохионы шон байршуулж, түүний арчлалт хамгаалалтыг хийдэг. Ийм дохионы шонгийн өндөр нь 0.75-0.8м байна. Харин хөдөлгөөн чиглүүлэх зурвас гаргасан хязгаарлагчийн өндөр нь 0.15-0.20 м-ээс хэтэрч болохгүй.
- 4.5. Хамгаалалтын хашлага, дохионы шонд хийх ээлжит үзлэг хийх, тэдгээрийн гэмтэлтэй элементийг засах, солих, бэхэлгээг чангалах, тоос шороог цэвэрлэх, угаах, шаардлагатай хамгаалалтын үед будах, гэрэл ойлгогч хуулга наах арга хэмжээ авах
- 4.6. Тэмдгийн иш, самбарыг угааж цэвэрлэх, тэмдгийн ар тал болон ишийг будах, тэмдэг заалт ишийг тэгшлэх, солих, боолтыг чангалах, гэрэл ойлгогч тэмдгийн гэрлийн үүсгүүрийг солих

- 4.7. Замын тэмдэгний арчилгааг жилийн турш тогтмол гүйцэтгэх бөгөөд, үүнд тэмдэг заалт дээрх шороо тоос шавар, өвлийн улиралд наалдсан цас мөсийг цэвэрлэх, түмбэ, хашлага хаалтны шавар шавхайг цэвэрлэх өнгийг сэргээх г.м ажил багтана. Харин тэмдэгний иш, түмбэ, хашлага хайс будах ажлыг хаврын улиралд гүйцэтгэх хэрэгтэй.
- 4.8. Авто зогсоолын өнгө үзэмшийг сайжруулж, хог шороог цэвэрлэх, хэвтээ тэмдэглэгээг сэргээх, тэмдэг заалтын будгийг сэргээн эвдэрсэн деталиудыг солих, жижиг эвдрэлийг засах.
- 4.9. Явган хүний замын гарцын шугамыг сэргээх, автобусны буудал, буудлын тоноглолуудыг цэвэрлэх, жижиг эвдрэлүүдийг засах, мөн түүнчлэн дуунаас хамгаалсан хийцүүдийн бүрэн бүтэн байдлыг хангах
- 4.10. Замын дэргэдэх бие засах газруудыг цэвэрлэх, халдваржилтаас сэргийлсэн бодисоор ариутгах, муу усыг соруулах, өнгө үзэмжийг сайжруулан будах, хаалга түгжээг сэлбэн засах, ус болон ариун цэврийн хэрэгсэлээр хангах, бие засах газрууд руу очих явган замын арчилгааг хийх
- 4.11. Замын дэргэдэх зогсоол дээрх сандал, ширээ, саравч, хамгаалалтын хана, хогийн савыг цэвэрлэх, бүрэн бүтэн байлгах, өнгө үзэмжийг нь сайжруулан будах, цэвэр усны цэгийн хамгаалалтыг сэргээн засах
- 4.12. Замын тооллого бүртгэлийн тоног төхөөрөмж, хяналтын видео камеруудын ашиглалтад үзлэг хяналт хийж, арчиж цэвэрлэх, бичлэгийн цэгийг тохируулах, бичлэгийг хуулж аваад илгээх, эвдрэлийн талаар шуурхай мэдээлэх
- 4.13. Авто замын гэрэлтүүлгийн шонгийн бүрэн бүтэн байдалд үзлэг шалгалт хийж шатсан гэрэл болон үүсгүүрийг солих холбогдох арга хэмжээ авах, шонг тэгшлэх, шавсан гэрлүүдийг солих, будах
- 4.14. Авто замын сөрөг хөдөлгөөний гэрлийн гялбалтаас сэргийлсэн төхөөрөмжүүдийн бүрэн бүтэн байдлыг хангах, тэгшилж засах, өнгө үзэмжийг нь сайжруулах
- 4.15. Замын дэргэдэх үйлчилгээний барилга байгууламжийн (зогсоол, бие засах газрууд, хогийн цэг буюу олон чиглэлийн цогц үйлчилгээний цэг г.м) бодит хэрэгцээг тодорхойлох, гарч байгаа зөрчлийг арилгах зорилгоор байнгын (жилд 2 удаа хавар, намар) үзлэг хийх шаардлагатай.
- 4.16. Замын дэргэдэх үйлчилгээний барилга байгууламжийн арчлалтын ажилд барилгын дээврийн бага хэмжээний эвдрэлийг засах, шат, шатны бариулыг бэхлэх , хаалга, цонх дулаалах, усны шугам хоолойн гоожилтийг тогтоох, төв халаалтын жижиг эвдрэлийг засах, хийн алдагдлыг арилгах, хийн зуухны унтраалгын краныг солих, шугам хоолойг будах, цахилгааны гэмтлийг засах, хогийн шугамыг цэвэрлэх, худгийг цэвэрлэх, эзэмшлийн талбайг байнга цэвэрлэж төв замаас салаалж байгаа туслах замын арчлалтыг хугацаанд нь гүйцэтгэж, явган хүний замыг байнгын арчилгаанд байлгах ажил орно.
- 4.17. Барилга байгууламжийн гадна тал болон хашаа хамгаалалтыг байнга будаж байх
- 4.18. Эзэмшлийн талбайг цэцэрлэгжүүлж , бут сөөг, мод, жимсний мод тарьж арчлах ажлыг тогтмол хийх.
- 4.19. Орчин үеийн шаардлагад замын тоноглол болон замын дэргэдэх үйлчилгээний барилга байгууламжийн арчлалтын ажил нь бүрэн механикжсан байх бөгөөд мэргэжлийн баг гүйцэтгэнэ.

4.20. Авто замын тэмдэг тэмдэглэгээ, тоноглол, замын дэргэдэх үйлчилгээний байгууллагын арчлалтын ажлын, төсвийн болон үйлдвэрлэлийн норм үнэлгээ ба Авто замын үзлэгийн аппликейшнд орсон эвдрэлийн код, ангиллыг Хүснэгт 4.1-д харуулав.

Хүснэгт 4.1. Норм үнэлгээ ба аппликейшнд орсон арчлалтын ажил ба эвдрэлийн код

Арчлалтын ажлын төсвийн ба үйлдвэрлэлийн нормд орсон ангилал	Авто замын үзлэгийн аппликейшнд орсон эвдрэлийн код
<ul style="list-style-type: none"> - Хамгаалалтын хашлага болон дохионы шонгуудын арчилгаа, тордолт - Хазайсан, унасан тоноглолыг засварлах - Тэмдгийн ховхорч хууларсан хэсгийг засварлах - Тэмдэг, мэдээллийн самбарыг засаж, арчлах - Тоноглолын суларсан боолт, бэхэлгээг чангалах - Авто зогсоол, явган хүний замын арчилгаа - Бие засах газруудын гадна доторх цэвэрлэгээ - Хог хуримтлуулан ангилах цэгийн арчлалт, цэвэрлэгээ - Замын зурвасын цэвэрлэгээ - Замын хяналтын видео камеруудын цэвэрлэгээ, арчлалт - Замын гэрэлтүүлэгийн чийдэн солих - ТАЦ-ын орчны цэвэрлэгээ, хаалт болон хяналтын камерын арчилгаа - Замын хамгаалалтын хийцүүдийн арчлалт, тордолт 	<ul style="list-style-type: none"> 2.2 Замын тэмдэг унасан, устсан, алга болсон, ш 2.3 Замын самбар хазайсан, хугарсан, гэмтсэн, ш 2.6 Замын тэмдэг заалтын бэхэлгээ эвдэрсэн, алга болсон, эрэг боолт суларсан, ш 2.7 Замын тэмдэг заалт, тоноглолд шавар тогтож бохирдсон, ш 2.8 Замын дохионы шон /түмбэ/ хугарсан, хазайсан, ш 2.9 Замын дохионы шонгийн будаг, гэрэл ойлгогч холцорсон, бохирдсон, м2 2.11 Замын камерын шон гулзайсан, камерын харах, бичих чиглэл өөрчлөгдсөн, ш 2.14 Замд зөвшөөрөлгүй заалт, самбар байршуулж, үзэгдэх байдлыг алдагдуулсан, ш 2.19 Замын дэргэдэх болон тусгаарлах зурвасын мод бутанд арчилгаа, тордолт хийгээгүй, ш 2.23 Замд түр байршуулсан хаалт, тэмдэг заалтуудыг зайлуулж, эвдэлсэн, ш 2.27 Замын зурваст байгаа хальтиргааны эсрэг материалыг зориулалтын бусаар ашигласан, м3

5. ЗАМЫН ТЭМДЭГ ТОНОГЛОЛЫН БОЛОН ЗАМЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН УРСГАЛ ЗАСВАР

- 5.1. Авто замын тэмдэг тэмдэглээний урсгал засварын ажлын бүрэлдэхүүнд тэмдэгний иш, самбарыг тэгшлэх, цэвэрлэх, будах, хуучин тэмдэглэгээг арилгах, шинээр тэмдэглэгээ хийх г.м ажлууд ордог.
- 5.2. Замын тэмдэг, тоноглолын засвар хийхээс өмнө засварын ажил хийгдэж байгаа талаар зам хэрэглэгчдэд мэдээлсэн түр тэмдэг, заалтууд тавина. Ажлаа дуусмагц авч шилжүүлэх юмуу хураана.
- 5.3. Замын тэмдэглэгээний 25% (термопластик), 50% (будаг)-с их нь элэгдэж арилж байгаа тохиолдолд дахин сэргээх ажил хийх. Хэрэв хуучин тэмдэглэгээ нь шинэ тэмдэглэгээний чанар, үзэгдэх байдалд муугаар нөлөөлөхгүй бол түүнийг арилгах шаардлагагүй.
- 5.4. Хуучин тэмдэглэгээг дараах аргаар арилгадаг:
 - Тэмдэглэгээ арилгадаг зориулалтын тоноглол бүхий машинаар, механик аргаар
 - Тусгайлсан хийн үлээгчээр, замын хучлага дээрх тэмдэглэгээг шатаах замаар арилгах
 - Замын тэмдэглэгээг даралтат хийн аргаар арилгах
 - Замын хучлагын одоо байгаа өнгөтэй ижил өнгөтэй будгаар будах (түр арилгах арга гэнэ)
- 5.5. Хуучин тэмдэглэгээг арилгахын тулд асфальтбетон хучлагын гадаргууг 2 мм-с илүүгүй гүнтэй зорж авахыг зөвшөөрдөг. Хуучин тэмдэглэгээг ховхолж авсны дараа үлдсэн гадаргуу нь хөдөлгөөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх ёсгүй.
- 5.6. Тэмдэглэгээг цэвэрхэн, хуурай гадаргуу дээр хийдэг. Зайлшгүй шаардлагаар нойтон гадаргуу дээр хийхээр бол, тусгай үлээдэг халаагчаар тэмдэглэгээг хийх гадаргууг жигд хатаана.
- 5.7. Цементбетон ба хуучин асфальтбетон гадаргуу дээр тэмдэглэгээ хийхийн тулд барьцалдагааг сайжруулах зорилгоор, халуунпласт, хүйтэнпласт, полимер туузаар тэмдэглэгээ хийх гадаргууг тусгай бэлдэцээр боловсруулдаг. Цементбетон хучлага бүхий зорчих зурвасын хэвтээ тэмдэглэгээ нь хучлагын дагуу заадастай давхцаж байвал, тэмдэглэгээг заадастай зэрэгцүүлэн хийхийг зөвшөөрдөг.
- 5.8. Гэмтсэн гэрэл ойлгогч хальсыг тэмдэгний самбарыг авахгүйгээр газар дээр нь сольдог. Үүний тулд самбарын гадаргуугийн тоос, тосыг шаардлагатай (бензин, ацетон г.м) материалын тусламжтайгаар цэвэрлэнэ. Сайтар цэвэрлэсэн гадаргуу дээр хальсыг нааж, зөөлөн гулгагчаар илүүрдэнэ.
- 5.9. Эвдэрсэн тэмдэг болон шонг засварын газарт засдаг. Авсан элементийн оронд тэр дор нь нөөц бэлдэцийг тавих хэрэгтэй.
- 5.10. Тэмдэгний нэг шон дээр өөр өөр заалт, мэдээлэлтэй тэмдэгүүд тавихыг хориглоно.
- 5.11. Нэг чиглэлийн замын тэмдэгний ишүүд нь салхины ачаалалд тэсвэртэй, угаахад тохиромжтой, мөргөхөд осол багатай, нэг хэлбэртэй, ижил материалаар хийгдсэн байх ёстой
- 5.12. Тэмдэг эргэсэн, ишээрээ хазайсан, гэрэл ойлгогч хальс гэмтсэн г.м жижиг эвдрэлүүдийг /ийм эвдрэл тун түгээмэл гардаг/ газар дээр нь дор нь засах хэрэгтэй.

Үзлэгийн автомашин иймэрхүү засварыг хийх багаж, тоног төхөөрөмж, материалтай байх ёстой.

- 5.13. Хаврын улиралд авто замын түр зогсоол, буудлуудын талбайд (хатуу хучилттай замд хагарал нүх, дугуйн мөрөөрх хотойлт, хайрган хучлага дээр дэргэжигнүүр, сул хайрга ялгарах, замын хашлага унах, хазайх, бие засах газрууд ажиллагаагүй болох, хог хуримтлагдах г.м) гарсан бага хэмжээний эвдрэлүүдийг, тусгай мэргэжлийн багаар 4, 5-р сард багтаан засварлах.
- 5.14. Зогсоолын орчмын явган хүний замын гарам, шат зэргийн эвдрэлийг засаж шинэчлэх
- 5.15. Замын хажуугийн уруй, үер, чулууны нуралт г.м-ээс хамгаалсан хийцүүд, мал амьтнаас хамгаалсан хашлага, хашааны эвдрэлийг засч, шинэчлэх
- 5.16. Хаалтын эвдэрсэн элементийг сольж, өнгө алдсан элементийн шороо шаврыг сайтар цэвэрлээд шинэчлэн будна. Металл болон төмөр бетон бүтэцийг нийлэг эмалиар буюу перхлорвинилтэй будагаар будах хэрэгтэй. Будахын тулд будаг шүршигч хэрэглэдэг.
- 5.17. Замын гэрэлтүүлгийн муруйсан хугарсан шонг авч тэгшлэх буюу солих, гэрэлтүүлгийн удирдлагын самбарыг цэвэрлэж будаад, ажиллагааг нь найдвартай болгох
- 5.18. Замын зурвас дахь сурталчилгааны самбар, хөшөө дурсгал, овоо, суварга г.м байгууламжуудыг, замын далан болон ухмалын хөмсөгнөөс гадагш 10м-с хол зайтай байршуулах бөгөөд эдгээрийн арчлалт, хамгаалалт, үзэмжийг өмчлөгч, эзэмшигч нь хариуцана.
- 5.19. Замын ашиглалтын бэлэн байдлыг хянах камерууд болон бусад төхөөрөмжүүдийн урсгал засварыг хийж, байнгын ажиллагаатай байлгах. Шаардлагатай тохиолдолд тэдгээрийн эд ангиудыг сольж шинэчилэх, байршлыг өөрчлөх.
- 5.20. Авто замын тэмдэг тэмдэглэгээ, тоноглол, замын дэргэдэх үйлчилгээний байгууллагын засварын ажлын, төсвийн болон үйлдвэрлэлийн норм үнэлгээ ба Авто замын үзлэгийн аппликейшнд орсон эвдрэлийн код, ангиллыг Хүснэгт 4.1-д харуулав.

Хүснэгт 5.1. Норм үнэлгээ ба аппликейшнд орсон засварын ажил ба эвдрэлийн код

Засварын ажлын төсвийн ба үйлдвэрлэлийн нормд орсон ангилал	Авто замын үзлэгийн аппликейшнд орсон эвдрэлийн код
- Дохионы төмөрбетон хугарсан шонг зайлуулж, шинээр солих	2.1 Замын тэмдэг заалт хазайсан, хугарсан, нугарсан, ш
- Тэмдгийн хугарсан, хуучин шон солих	2.4 Замын хэвтээ тэмдэглэгээ /цагаан зураас/ бүдгэрсэн, арилсан, у/м
- Дохионы модон шонг зайлуулах	2.5 Замын тэмдэг заалтын тоо үсэг бүдгэрсэн, ховхорсон, холцорсон, гэрэл ойлгохгүй болсон, ш
- Дохионы төмөрбетон шонг зайлуулах	2.10 Замын камер ажиллахгүй болсон, ш
- Замын тэмдгийн эвдэрсэн суурийг бетондох	2.12 Замын хайс хашлага муруйсан, хугарсан, унасан, хазайсан, у/м
- Авто замын тэмдгийн шороон призм байгуулах, засварлах	
- Мэдээллийн самбарын хугарсан, хуучин хөл суурийн хамт солих	

- Замын тоноглолын металл хийц будах	2.13 Явган замын хашлага унасан, хазайсан, муруйсан, у/м
- Замын тэмдгийн эвдэрсэн суурийг бетондох	2.15 Замын хашлага, хайсны өнгө будаг алдагдсан, м2
- Замын тэмдгийн төмөр самбар будах	2.16 Замын хажуугийн хамгаалалтын /уруйн, хамгаалалтын, бэхэлгээний, ус
- Замын тоноглолын металл хийц будах	залах г.м/ хийцүүд эвдэрсэн, гэмтсэн, у/м
- Дохионы төмөрбетон шон будах	2.17 Замыг цаснаас хамгаалах хийцүүд унасан, алга болсон, эвдэрсэн, ажиллахгүй байгаа г.м, у/м
- Замын тоноглолын төмөрбетон хийц будах	2.18 Замын дэргэдэх мод бутыг дайрч сүйтгэсэн, ш
- Мэдээллийн самбарын бичлэгийг засаж сэргээх	2.20 Эсрэг чиглэлийн машины гялбаанаас хамгаалсан хийцүүд ажиллахгүй болсон, у/м
- Замын тоноглолын металл хийцийг жигдэлж солих	2.21 Мөнх цэвдгийг хөлдөөх төхөөрөмжийг эвдэлсэн, ш
- Замын тэмдэг, мэдээллийн самбарыг жигд томруулан шинэчилж байрлуулах	2.22 Агааржуулагч цоргыг гэмтээсэн, ш
- Авто замын байдлын мэдээлэл дамжуулах камер байрлуулах, шилжүүлэх, шинэчлэх	2.24 Замын гэрэлтүүлэгийн шон эвдэрсэн, ш
- Авто замын тоноглолын эвдрэл, гэмтэл, байршил	2.25 Замын хажуугийн явган хүний зам эвдэрсэн, м2
- Хуучин мэдээллийн самбарыг солих	2.26 Замын хажуугийн дугуйн зам эвдэрсэн, м2
- Тэмдэгийн хуучин самбарыг солих	

6. ЗАМЫН ТЭМДЭГ ТОНОГЛОЛЫН БОЛОН ЗАМЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ЭЭЛЖИТ ЗАСВАР

- 6.1. Замын тоноглолын ээлжит засвараар шинээр хамгаалалтын хашилт хийх, замын тэмдэг болон чиглүүлэгч бүтээцийг солих юмуу шинээр тавьдаг. Хашилтын засварыг зарим хийцийн элементүүдийг солих замаар гүйцэтгэх.
- 6.2. Авто замын хэвтээ тэмдэглэгээг 2 жил тутам тогтмол шинэчлэх, хэрэв төлөвлөгөөт үзлэгээр шинэчлэх шаардлагагүй гэж үзвэл энэ хугацааг нэг жилээр сунгаж болно.
- 6.3. Зарим уулзвар, огтлолцол, амралтын талбай, автомашины зогсоол, түүнчлэн дурсгалт газруудыг тохижуулах, худаг гаргах, эрчим хүч, цэвэр бохир усны болон халаалтын системтэй болох.
- 6.4. Замын үйлчилгээний түвшин дээшилсэнтэй холбогдуулан, замын тэмдэг тэмдэглэгээ, тоноглолыг орчин үеийн шаардлагад нийцүүлэн иж бүрэн шинэчлэх
- 6.5. Авто замын дэргэдэх зогсоол, бие засах газрууд, угаалгын байр, хог хуримтлуулах, ангилах цэгийн ээлжит засварыг хийх, шинэчлэн байгуулах. Олон улс, улсын чанартай

замуудад байршуулах үйлчилгээний цогцолборууд, түр зогсоолуудын хоорондын жишиг зайг Хүснэгт 6.1-д харуулав.

- 6.6. Авто замын хучлагад хийсэн гадаргуугийн боловсруулалт-ээлжит засварын төрлөөс хамааруулан замын хэвтээ тэмдэглэгээг шинэчлэн хийх, замын нөхцөл байдал сайжирсантай холбоотойгоор замын хөдөлгөөн зохицуулалтын зарим тэмдэгүүдийг сольж өөрчлөх
- 6.7. Овоо, байгалийн үзэсгэлэнт, дурсгалт газар, автобус зогсох цэгүүдэд зогсоолын талбайг зам өргөсгөх замаар байгуулж, холбогдох тэмдэг тэмдэглэгээ, заалт, тоноглолоор тохижуулах, бие засах газрууд, хогийн цэг, ариун цэврийн байгууламж бий болгох

Хүснэгт 6.1. Түр зогсоолын болон үйлчилгээний цогцолбор объектуудын байршил

Түр зогсоолын болон үйлчилгээний цогцолборын төрөл	Объектуудын хоорондын зай, км
1. Зогсоолын (жижиг) ¹ талбай, бие засах газрууд, ариун цэврийн өрөө, хоолны газар, хог хуримтлуулах, ангилах цэг	30-40
2. Зогсоолын (том) ² талбай, бие засах газрууд, ариун цэврийн өрөө, машин угаах газар, техникийн үйлчилгээний станц (дугуй засвар), хоол худалдааны газар, хог хуримтлуулах, ангилах цэг, хүүхдийн тоглоомын талбай, ШТС	60-80
3. Олон чиглэлийн үйлчилгээний нэгдсэн цогцолбор ³	100-150
<p>¹ – зогсоолын жижиг талбай гэж, 10-20 тээврийн хэрэгсэл, үндсэн зам чөлөөлөн зогсох боломжтой, орц гарцаар тоноглогдсон, 10 км-ын алсаас эхлээд байршилд ойртож байгааг заасан тэмдэг заалттай, талбайг хэлнэ.</p> <p>² -зогсоолын том талбай гэж, 21-50 хүртэл тооны, үүний 20%-50% нь том автобус, ачааны тээврийн хэрэгсэл, чиргүүлтэй машинд зориулагдсан, орц гарцаар тоноглогдсон, 20 км-ын алсаас эхлээд байршилд ойртож байгааг заасан тэмдэг заалттай, хатуу хучилттай талбайг хэлнэ.</p> <p>³ -үйлчилгээний нэгдсэн цогцолбор гэж, 2-т заасан үйлчилгээний цэгүүд, тоноглолтой, дэргэдээ ТАЦ-тэй, 40-60 машины том зогсоолтой, амралтын талбайтай, орон нутгийн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаатай, гэрийн тэжээвэр амьтдыг салхилуулах боломжтой цэгийг хэлнэ.</p>	

- 6.8. Замын уулзвар, огтлолцол зэрэг замын байгууламжийн тэмдэг тэмдэглэгээг шинэчлэх, иж бүрэн тоноглолтой болгох
- 6.9. Шаардлагатай газруудад авто замын түмбийг ган туузан хашлагаар солих, ган туузан хашлагыг түмбээр солих
- 6.10. Авто замын ашиглалтын байнгын бэлэн байдлыг хангах Зам хариуцагчдын шуурхай ажлын байр байгуулах
- 6.11. Бярваазуудын засвар үйлчилгээг тогтмол хийх

7. ЗАМЫН ТЭМДЭГ ТОНОГЛОЛЫН БОЛОН ЗАМЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ИХ ЗАСВАР

Замын тэмдэг тоноглолын болон замын үйлчилгээний барилга, байгууламжийн их засварыг шороон далан, замын хучилтын болон хиймэл байгууламжуудын их засвартай хамтад нь гүйцэтгэдэг. Их засварын явцад замын тоноглолын байдлыг тухайн зэрэглэлийн авто замд тавигддаг орчин үеийн шаардлагын хэмжээнд хүргэдэг.

Их засварын үед дараах ажлуудыг гүйцэтгэнэ:

- 7.1. Хуучин байсныг сэргээх болон чиглүүлэгч бүтээц, замын тэмдэг хаалт хашилтыг шинээр хийх
- 7.2. Шаардлагатай газруудад зогсоолын, буудлын талбай павильон, амралтын болон автомашины зогсоолын зориулалтын талбай, явган зорчигчийн гарам (олон түвшингийнхийг оруулаад), суурин газруудаар өнгөрөх хэсэг дээр явган зорчигчийн болон дугуйн зам барих
- 7.3. Хуучин байсныг өөрчлөн сэргээх болон авто замын огтлолцол, уулзварыг нэг болон олон түвшинд бий болгож байгуулах, замын туршид буюу зарим хэсэг дээр эргэц, гарц, гарам гаргах, замын үйлчилгээний байгууллагууд болон дурсгалт газрууд руу очих (урт нь 200м-ээс ихгүй) зам барих
- 7.4. Замын зурваст гинжит техникийн зуны хуучин замыг сэргээх буюу шинээр барих
- 7.5. Зам ашигласны төлөөх төлбөр хураах цэгүүдийг шинээр байгуулах, хуучныг тоноглох, зарим хэсэг дээр гэрэлтүүлэг хийх, замын үйлчилгээний цэгүүдийг интернет холбоотой болгох
- 7.6. Хөдөлгөөний эрчмийн автомат тоолууруудыг шинээр байрлуулах, байсныг нь шинэчлэх, замын техник ашиглалтын байдлыг тодорхойлох шинжилгээ, судалгааны байнгын тоноглолуудыг байршуулах, замын онцгой хэсгүүдийг камержүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах
- 7.7. Авто замд мал амьтны гарц шинээр байгуулах буюу зарим дугуй хоолойг мал амьтан гарах боломжтой болгон шинэчлэх
- 7.8. Авто замын арчлалт, засварын шуурхай хэсгүүд, диспетчерийн удирдлагын байр барих
- 7.9. Авто замын зарим хэсгийг мэдрэгчийн удирдлага бүхий гэрэлтүүлэгтэй болгох
- 7.10. Замын дэргэд, халтиргааны эсрэг бодис бэлтгэх талбай, хадгалах агуулах барих
- 7.11. Замд архитектур-уран сайхны чиглэлийн элементүүд бий болгох г.м.

Дээр дурдагдсан бүх ажлуудыг тусгай төслийн үндсэн дээр хэрэгжүүлнэ.